



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР**

Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011  
Утас: 32-04-61, Факс: (976-11) 32-18-08  
<http://www.uda.ub.gov.mn>

2020.04.29 № 02/1595  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ**

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дугаар сарын 20-ний өдрийн А/528 дугаар захирамжийн дагуу “Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл” боловсруулах ажлын даалгаврыг хүргүүлж байна.

Хавсралт 18 хуудастай.

ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ




Б.УУГАНБАЯР

**БАТЛАВ.**

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР  
БӨГӨӨД НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

Б.УУГАНБАЯР



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН  
ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, БАРИЛГАЖИЛТЫН ТӨСӨЛ  
БОЛОВСРУУЛАХ ЗУРГИЙН ДААЛГАВАР**

2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр

Дугаар № ЕТ-2020/04

Улаанбаатар хот

1.	Ерөнхий агуулга	<p><b>Ерөнхий төлөвлөгөө боловсруулах үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Их хурлын 2013 оны 23 тоот тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага;</li><li>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 133 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн үйлдвэрлэл, технологийн парк хөгжүүлэх хөтөлбөр”;</li><li>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр;</li><li>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 04 тоот тогтоолоор батлагдсан Багахангай дүүргийн “Хөнгөн үйлдвэрийн, үйлдвэрлэл технологийн парк”-ийн техник эдийн засгийн үндэслэл;</li><li>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 28/27 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл;</li><li>- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/528 дугаар захирамж;</li></ul> <p><b>Зургийн даалгаврын зорилго:</b></p> <p>Улаанбаатар хотын хүн амын нягтралыг задлах, Багахангай дүүрэгт шинээр ажлын байр бий болгох, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Үйлдвэрлэл технологийн паркийг байгуулахад шаардлагатай эдийн засгийн үндэслэлтэй орон зайн оновчтой төлөвлөлттэй хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах,</p>
2.	Хамрах хүрээ, ажиллах хүч	<p><b>Төлөвлөлтийн хязгаар, хамрах хүрээ:</b></p> <p>Багахангай дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт Багахангай дүүргийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан 56 га талбайд төлөвлөлт хийнэ.</p> <p><b>Ажиллах хүч:</b></p> <p>Багахангай дүүргийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн техник эдийн засгийн үндэслэлийн дагуу эхний ээлжид 500 гаруй ажлын байр бий болно.</p>
3.	Гүйцэтгэх байгууллага	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, түншлэл</p>

4.	Захиалагч байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалт, хөгжлийн газар</li> <li>- “Багахангай үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ</li> </ul>
5.	Боловсруулах үе шат	<ol style="list-style-type: none"> <li>1. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө <ul style="list-style-type: none"> <li>- Судалгаа, үнэлгээ</li> <li>- Төлөвлөлт, тооцоолол</li> </ul> </li> <li>2. Барилгажилтын төсөл</li> </ol>
6.	Боловсруулах хугацаа	<p>Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулснаас хойш хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах нийт хугацаа 120 хоног байна. /Тус хугацаанд магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэх хугацаа ороогүй болно./ Үүнээс:</p> <p><b>Эхлэлийн тайлан: /45 хоногт гүйцэтгэх/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан үйлдвэрлэл, цаашид нэмэгдэх үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа дууссан байх, төлөвлөлтийн шийдлийг гаргаж бүсчлэл, логистик тээвэр, инженерийн дэд бүтцийн хангамжийн шийдэл, паркийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн байх;</li> </ul> <p><b>Дундын тайлан: /45 хоногт гүйцэтгэх/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эхлэлийн тайланд өгсөн санал, зөвлөмжийг тусгаж барилгажилтын төсөл, хөрөнгө оруулалтын тооцоо, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, паркийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдсэн байх;</li> </ul> <p><b>Эцсийн тайлан: /30 хоногт гүйцэтгэх/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий төлөвлөгөөнд мэргэжлийн байгууллагаас өгсөн санал, дүгнэлтийг тусгаж эцсийн байдлаар хүлээлгэн өгөх /Багахангай дулааны станц ОНӨҮГ, Багахангай Ус суваг ашиглалтын товчоо, ХБХГ, НШУҮИГ, БҮТП/</li> </ul>
7.	Барилгажилтын төсөлд тавигдах шаардлага	<p><b>Архитектур орон зай:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Багахангай дүүргийн хөгжлийн чиг хандлага, Багахангай дүүргийн Үйлдвэр, технологийн паркийн техник эдийн засгийн үндэслэл, ирээдүйн үйлдвэрлэлийн чиг хандлагын дагуу нөөц бүсүүдийн зориулалтыг тодорхой тусгах;</li> <li>- Орон зайн бүсчлэлийн тогтолцоо, тээвэр логистикийн сүлжээг боловсронгуй болгох;</li> <li>- Багахангай дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркийн төлөвлөлтийг боловсруулахдаа нутаг дэвсгэрийн ашиглалт байгаль-экологитой уялдуулах;</li> <li>- Бүсчлэл тус бүрээр тавигдах үндсэн шаардлага болон газар ашиглалтын үүрэг, зориулалт, барилгын өндрийн дээд хязгаар буюу оврын хэмжээ нягтралыг тодорхойлох;</li> </ul> <p><b>Эдийн засгийн тооцоо:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх, зах зээлийн эрэлт, ирээдүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн паркийн төлөвлөлтийг боловсруулах нөхцөл байдлын шинжилгээ хийж хүчин чадлыг тодорхойлох;</li> <li>- Багахангай дүүргийн Үйлдвэр, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын тооцоог батлагдсан норм ба дүрмийн дагуу хийх;</li> <li>- Хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмж, менежментийн төлөвлөгөө боловсруулах;</li> </ul>

		<p><b>Гудамж, замын сүлжээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Багахангай дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гудамж замын сүлжээтэй уялдуулна. Төлөвлөлтийг боловсруулахдаа паркийн орон зайн тогтолцоо, ажиллах хүчний өсөлт, тээврийн хөдөлгөөний эрчим, тэдгээрийн байнга өсөн тэлж байх явцтай уялдуулах;</li> <li>- Улаанбаатараас зүүн гурван аймаг, дүүргийн суурьшилтай холбох тээвэр логистик төв, авто замыг төлөвлөх;</li> <li>- Нийтийн тээврийн зогсоол болон эцсийн зогсоолын орон зайн, байршлыг тогтоож норм дүрмийн дагуу төлөвлөх;</li> </ul> <p><b>Үйлчилгээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Багахангай дүүргийн аж үйлдвэр, технологийн паркийн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан ажиллах хүчний тоог үндэслэл болгох;</li> <li>- Аж үйлдвэр, технологийн паркийн ажилчдад зориулсан ахуйн үйлчилгээний барилга, байгууламжийг төлөвлөх;</li> <li>- Аж үйлдвэр, технологийн паркийн захиргаа, бизнес төв бүхий барилгын материалын шинжлэх ухааны төв инновацын хөгжлийн төвтэй байхаар төлөвлөх;</li> </ul> <p><b>Үйлдвэрлэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Багахангай үйлдвэрлэл технологийн паркийн үйлдвэрүүдийг үйл ажиллагаагаар нь нэгтгэж кластер хэлбэрээр төлөвлөх;</li> <li>- “Багахангай үйлдвэрлэл технологийн парк”-д байгальд халгүй өндөр технологи бүхий эко үйлдвэрүүдийг төлөвлөх;</li> <li>- Үйлдвэрлэл явуулах барилгаас гадна тээвэр зуулчлал баталгаат агуулах, сургалтын төв, шинжлэх ухаан-туршилтын төв лаборатори зэргийг төлөвлөх;</li> </ul> <p><b>Ногоон байгууламж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрийн бүсийн цэцэрлэгжүүлэлтийг хүн амын ажиллаж амьдрахад тохиромжтой гоо зүй, ариун цэвэр-эрүүл ахуйн нөхцлийг хангасан, орон зайн бичил уур амьсгалын тааламжтай орчинг бий болгож хүний үйл ажиллагааны элдэв хортой нөлөөллөөс хамгаалах, барилгажсан нутаг дэвсгэрийн архитектур-орон зайн зохиомжийг сайжруулсан байхаар тооцож төлөвлөх;</li> <li>- Үйлдвэрийн бүсийг төлөвлөхөд үүрэг зориулалт, хүчин чадлыг тодорхойлж тухайн үйлдвэрийн онцлогийг харгалзан тусгай хамгаалалтай бүсээс хамгаалалтын ногоон зурвас татах;</li> </ul>
8	Дэд бүтцэд тавигдах шаардлага	<p><b>Хог хаягдал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрүүдийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, зайлуулах, дахин ашиглах, устгах, тусгай цэг байгуулах менежментийн төлөвлөлтийг боловсруулах;</li> </ul> <p><b>Ачаа тээвэр:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэл технологийн паркийн үйлдвэрлэлийн бүс, агуулахын аж ахуй, логистик төвтэй төлөвлөх;</li> </ul>

- Үйлдвэрлэл технологийн паркийн түүхий эдийн хангамжийг татах авто зам болон бусад эх үүсвэрийн боломжийг судалж төлөвлөлтийг нарийвчлах;
- Төмөр замын тээврийг ашиглан түүхий эд, бараа материал хүлээн авах, бэлэн болсон бүтээгдэхүүнээ түгээх боломжийг тусгах;
- Багахангайд дүүргийн ашиглалтгүй цэргийн нисэх онгоцны буудлын зурвасыг ашиглах боломжийг судалж төлөвлөлтөд концепц тусгах;

**Инженерийн бэлтгэл арга хэмжээ:**

- Төлөвлөгдсөн талбайд судалгаа, инженер геологи, гидрогеологи, гидрологийн тооцоо судалгаа хийж үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний усны түвшин доошлуулах шүүрүүлийн байгууламж, зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээ төлөвлөлтийн тооцооллыг нарийвчлах.
- Болзошгүй үерийн аюулыг 1, 5, 10%-ийн хангамжийн зарцуулалтыг тодорхойлж, үерийн зардлыг 1%-ийн хангамжаар тооцож бодно.
- Инженерийн бэлтгэл арга хэмжээний байгууламжийн инженерийн тооцоог хамгийн боломжит хувилбарыг сонгож сүүлийн үеийн дэвшилтэт технологи ашиглан аль болох бага зардалтай байхаар төлөвлөх.
- Инженерийн бэлтгэл арга хэмжээний байгууламжид нийлэх гуу жалга түүний оруулга, бэхэлгээний хийцийн тооцоо, хатуу урсцын тооцоог нарийвчлан боловсруулах .
- Инженерийн бэлтгэл арга хэмжээний байгууламжийн ашиглалт, техникийн засвар үйлчилгээнд зориулан явган хүний зам, авто машины гүүр, явган хүний гүүр зэргийг орчны тохижилт төлөвлөлттэй уялдуулан норм дүрмийг ханган төлөвлөх.
- Байгууламжийн аюулгүй ажиллагааг хангаж хамгаалалтын зурвас тогтоох, хөрсний нуралтаас сэргийлэх эргийн бэхэлгээ хийх
- Гадаргын болон газрын доорх ус ашиглах тооцоо, боломжийн судалгаа, туршилт судалгааны ажил боловсруулах.

**Дулаан хангамж:**

- Багахангай дүүргийн хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ-ийн хэрэгжилттэй уялдуулан дулаан хангамжийн ачааллыг үе шат бүрээр нарийвчлан төлөвлөх. Дулааны эх үүсвэр, дулааны станцын хүчин чадлыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шаттай уялдуулан тооцож хөрөнгө оруулалтыг үе шат бүрээр нарийвчлан тооцох.
- Шугам сүлжээг хонгилын нэгдсэн системд төлөвлөх
- Дулаан хангамжийн системийн төлөвлөлтийн бүх шатанд Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах бодлогыг баримтлах , зөвлөмж боловсруулах

*Дулааны эрчим хүчний эх үүсвэр нь дараах хувилбаруудтай байна.*

*Үүнд:*

- Дэвшилтэт технологи бүхий сайжруулсан түлшээр ажиллах боломжтой бие даасан эх үүсвэрээс дулааны эрчим хүчээр хангагдах

- Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан, био масс, хийн түлшээр хослон ажиллах боломжтой дулааны эх үүсвэрээс хангагдах
- Хийн түлшээр ажиллах эх үүсвэрээс хангагдах
- Хийн түлшийг барилга бүрт түгээж, дулаан хангамжийг бие даасан байдлаар хэсэгчилэн шийдвэрлэх хувилбарыг судлах
- Газрын гүний дулааны эрчим хүчний эх үүсвэр ашиглах нөхцөлд, эрчим хүчний эх үүсвэрийн 75-аас дээш хувийг газрын гүний энерги ашиглаж гаргах боломжтой судалгаагаар батлагдсан байх.
- Эрчим хүчний эх үүсвэрүүдийн үйлдвэрлэх эрчим хүчний параметр, тоноглолын сонголт болон бусад шаардлагатай эдийн засгийн өгөөжийн тооцоог хийх.

***Дулааны эх үүсвэрт тавигдах шаардлага:***

- Дулааны эх үүсвэрүүдийн ашигт үйлийн коэффициент нь 75 хувиас дээш байх /Дулааны эх үүсвэрийн дотоод хэрэгцээ, цахилгаан зарцуулалт нь хамгийн бага байх хувилбар, технологийг дэвшүүлсэн байх/
- Түлшийг тээвэрлэх зардал нь хамгийн бага өртөгтэй байх хувилбарыг сонгох,
- Түлш тээвэрлэх тээврийн сүлжээг бүрэн шийдвэрлэсэн байх
- Түлш хадгалах, нөөцлөх асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байх
- Бүрэн автомжуулсан системтэй буюу хүний оролцоо бага байх технологи нэвтрүүлсэн байх
- Дулааны эх үүсвэрийн байршил нь байгаль орчин, хөрс, ус хангамж, цахилгаан хангамжийн асуудлыг бүрэн судлаж шийдвэрлэсэн байх

***Дулаан хангамжийн сүлжээнд тавигдах шаардлага***

- Ус дулаан хуваарилах төв, сүлжээний төлөвлөлтийг гидравлик горимын хувьд хамгийн ашигтай хувилбарыг гаргаж төлөвлөх
- Газрын гадаргын өндөржилт, барилгын өндрийн бүсийн төлөвлөлттэй уялдуулан нэгдсэн ус дулаан дамжуулах төвийг төлөвлөх
- Нэгдсэн ус дулаан дамжуулах төвүүд дээр сүлжээний буцах усны энергийг ашиглан шалны халаалтын системд ашиглах боломжийг судлах
- Хэрэгцээний халуун усны эх үүсвэрийн шийдлийг сэргээгдэх эрчим хүчний болон төвлөрсөн дулаан хангамжийн системийн шийдэлтэй хосолсон байдлаар шийдвэрлэх техникийн шийдэл гаргах

***Цахилгаан хангамж***

- Цахилгаан хангамжийн 2 талын тэжээлтэй байхаар төлөвлөлтөнд тусгах
- Нөөц тэжээлийн эх үүсвэрийг холбогдох нормын дагуу төлөвлөх.
- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулан цахилгаан хангамжийн төлөвлөлтийг үе шаттай гүйцэтгэн, цахилгааны нийт ачааллыг нарийвчлан тооцож хөрөнгө оруулалтын тооцоог үе шаттай боловсруулах,
- Цахилгааны нийт ачаалалд үндэслэн, ЦДҮС ТӨХК, УБЦТС ТӨХК-тай зөвшилцсөний үндсэн дээр 110/35/10 кВ-ын дэд станц, эсвэл 35/10 кВ-ын дэд станц тус бүр 1 иж бүрдлийг шинээр барихаар төлөвлөх,

- Тус дэд өртөөнөөс түгээх сүлжээний 10кВ-ын кабель шугам Хуваарилах байгууламж, хаалттай дэд өртөөнүүд барьж цахилгаан эрчим хүчээр хангах.
- Шинэ суурьшлын бүсийн зам гудамж, талбайг гэрэлтүүлэхэд сэргээгдэх эрчим хүчний дэвшилтэт техник, технологийг ашиглах,
- Суурьшлын бүсийн цахилгааны шугам сүлжээг бусад инженерийн шугам сүлжээний хонгилын системтэй уялдуулан төлөвлөх.
- Цахилгаан эрчим хүчний нийт ачааллын 30 хүртэлх хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах хувилбар тооцох

**Усан хангамж:**

- Ундны усыг гүний усны эх үүсвэр, технологийн шийдэл болон газрын байршил, хил хязгаар, хэрэглээний боломжийг тодорхойлсон байх
- Хэрэглээний усны төрөл ангиллыг тодорхой болгох, хэрэглэгчийн ачааллын тооцоог нарийвчлан тусгах
- Ундны усны MNS ISO 24511:2012 стандартын шаардлагыг хангасан байх
- Ундны усны хамгаалалтын зурвасыг мөрдүүлэх
- Усны дахин ашиглалт /саарал ус/-ын системийн нэвтрүүлэх боломжийг хувилбар бүрд тооцож үзэх
- Хур тунадасны усыг хуримтлуулах улмаар бичил усан толио үүсгэх, цэвэр усны нөөцийг зүй зохистой ашиглах, усны хэрэглээг багасгах зэрэг үйл ажиллагааг дэмжсэн зөвлөмж, санал дүгнэлт хавсаргах

**Ариутгах татуурга:**

- Ариутгах татуургын бие даасан эх үүсвэрүүдийг газрын байршил, налуу, геологийн тогтцоос шалтгаалан сонгосон байх
- Цэвэрлэгээний технологи, бохир усны гаргалгаа, оролт, шугамын налуу зэргийг анхан шатны зургийн хэмжээнд сонгосон байршил бүрд оновчтой төлөвлөх, төлөвлөлтийн шаардлагуудыг зөвлөмж хэлбэрээр хавсаргах
- Цэвэрлэх байгууламжийн технологийн шийдэл нь паркийн хэрэглээтэй уялдсан техник эдийн засгийн хувьд үр ашигтай өргөтгөх боломжтой технологи сонгох
- Төлөвлөж буй ариутгах татуургын шугам сүлжээнд одоо болон хэтийн төлөвлөлтөөр холбох хэрэглэгчдийн ачааллыг тусгасан байх
- Цэвэрлэгдсэн усны резервуар төлөвлөх цаашид шинэ технологи нэвтрүүлэх шугам сүлжээний трасс татах боломжтой байрлалд байршуулах илүүдэл усыг далан сувагт хийх
- Ахуйн болон үйлдвэрийн бохир усны системийг тусад нь төлөвлөх.
- Цэвэрлэх байгууламжаас гарсан усыг үйлдвэрийн технологийн усанд ашиглах, саарал усны систем төлөвлөх

**Холбоо, мэдээлэл:**

- Төлөвлөлтийн бүсийн хүн ам, өрхийн нягтралыг харгалзан кабелийн дамжуулал болон сүлжээ төлөвлөлтэй уялдуулан Мэдээлэл технологи шуудан харилцаа холбооны газраас 2015 оны 05 дугаар сарын 12-ний өдөр гаргасан зөвлөмжийн дагуу Мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн үйлчилгээний төв байгуулахаар төлөвлөх.

		<ul style="list-style-type: none"> <li>- Хот хоорондын дамжуулах сүлжээний шилэн кабелиас холболт хийж, шинээр төлөвлөж буй Мэдээлэл холбооны нэгдсэн төвийг дамжуулах сүлжээнд холбох</li> <li>- Төлөвлөлтийн бүсэд гол сувагчлалыг 4-6 яндантай, салбар сувагчлалыг 2-4 яндантай байхаар төлөвлөх,</li> <li>- суурьшлын бүс дотор 24-48 core шилэн кабелийг тарааж суурилуулахаар төлөвлөх</li> <li>- Дохиолол хяналтын нэгдсэн системийг авто замын сүлжээтэй уялдуулан төлөвлөх.</li> <li>- Төрийн үйлчилгээ болон бусад үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх үндсэн суурь сүлжээг тооцож 48 шөрмөсөөс багагүй шилэн кабелийн цагираг сүлжээ байгуулах.</li> </ul>
9	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Багахангай дүүргийн үйлдвэрлэл технологийн паркийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийж баталгаажуулах;</li> <li>- Багахангай дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Багахангай дүүргийн хөнгөн үйлдвэр, технологийн паркийн техник эдийн засгийн үндэслэлийн дагуу төлөвлөлтийг нарийвчлан боловсруулах;</li> <li>- Багахангай дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркийн ТЭЗҮ-д тусгагдаагүй ирээдүйд хөгжүүлэх боломжтой үйлдвэрүүдийг эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгах,</li> <li>- Инженерийн дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэхдээ Багахангай дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, шугам сүлжээний газруудтай зөвшөөрөлцөж, урьдчилсан байдлаар санал авсан байх;</li> <li>- Төлөвлөлтийн шийдлийг үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээг 5 жилийн давтамжтайгаар тодорхойлон, хөрөнгө оруулалтын тооцоо гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх санал боловсруулах;</li> <li>- Гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлтөд тусгах;</li> <li>- Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломжийг судалж тусгах;</li> <li>- "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ын дагуу эх загвар зураг /эскиз/, ерөнхий төлөвлөгөөг дүүргийн засаг захиргаа, иргэд, аж ахуйн нэгж байгууллага, нийслэлийн холбогдох байгууллагуудаас санал авч тусгах;</li> </ul>
10	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p><b>Монгол Улсын хуулиуд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;</li> <li>- Хот байгуулалтын тухай хууль;</li> <li>- Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;</li> <li>- Барилгын тухай хууль;</li> <li>- Усны тухай хууль;</li> <li>- Монгол Улсын Инновацийн тухай хууль;</li> <li>- Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам;</li> <li>- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль;</li> </ul>



		<p><b>Норм, нормативууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-04);</li> <li>- Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09);</li> <li>- Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-102-07);</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм;</li> <li>- Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө (БНБД 30-02-07)</li> <li>- Хот суурины гудамж, зам төлөвлөлт (БНБД 32-01-04)</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм;</li> <li>- Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам; (ЗТБХБ-ын сайдын 183 дугаар тушаал)</li> <li>- Үйлдвэрийн барилга (БНБД 31-11-09)</li> <li>- Үйлдвэрийн газрын байгууламж (БНБД 31-16-11)</li> <li>- Агуулахын барилга (БНБД 31-19-10)</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм, заавар;</li> </ul>
11	Зураг төслийн иж бүрдэл	<p><b>Бичиглэлийн материал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тайлбар бичиг;</li> <li>- Барилгажилтын төслийн тайлбар бичиг;</li> <li>- Инженер геологийн дүгнэлт;</li> <li>- Товч танилцуулга;</li> </ul> <p><b>Зураглалын материал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байршлын схем М1:1000;</li> <li>- Орчны тойм М1:1000;</li> <li>- Дэвсгэр зураг; М1:1000;</li> <li>- Судалгаа, одоогийн байдал М1:1000;</li> <li>- Газар ашиглалтын талбайн баланс М1:1000;</li> <li>- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл М1:1000;</li> <li>- Барилгажилтын төслийн төлөвлөлтийн шийдэл М1:2000;</li> <li>- Барилгажилтын төслийн эх загвар зураг М1:100- М1:200;</li> <li>- Барилгуудын эх загвар зургийн хувилбар боловсруулах М1:100; <ul style="list-style-type: none"> <li>-Байгуулалт М1:100;</li> <li>-Огтлол М1:100;</li> <li>-Фасад М1:100;</li> </ul> </li> <li>- Зам тээврийн сүлжээ, логистик төлөвлөлт М1:2000;</li> <li>- Ногоон байгууламжын төлөвлөлт М1:2000;</li> <li>- Хог хаягдлын менежментийн төлөвлөлт М1:2000;</li> <li>- Гамшгийн менежментийн төлөвлөлт М1:2000;</li> <li>- Инженерийн дэд бүтцийн хамгаалалтын зурвас М1:2000;</li> <li>- Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэл М1:2000;</li> <li>- Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт, улаан шугам М1:1000;</li> <li>- Дулаан хангамжийн төлөвлөлт М1:2000;</li> <li>- Ус хангамж, ариутгах татуургын төлөвлөлт М1:2000;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Цахилгаан хангамжийн төлөвлөлт M1:2000;</li> <li>- Холбоожуулалтын төлөвлөлт M1:2000;</li> <li>- Хэрэгжих хугацаанд барилгажилтыг үе шатаар хэрэгжүүлэх шатыг зураглалаар үзүүлэх M1:2000;</li> <li>- Барилгажилтын төслийн ерөнхий харагдах байдал /3D зураг/</li> <li>- Барилгажилтын төслийн онцлогийг харуулсан анимэйшн /2 минут/</li> <li>- Макет M1:1000;</li> <li>- Бусад;</li> </ul> <p><b>Зураг төсөлд тавигдах шаардлага:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага /Хавсралт-2-ын дагуу хийх/</li> </ul>
--	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

**ТАНИЛЦСАН:**


ШИНЖЛЭХ УХААН, ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ИННОВАЦИЙН ГАЗРЫН ДАРГА



Б.МӨНХ-ОРГИЛ

**ХЯНАСАН:**

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЕРӨНХИЙ  
АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



А.БАТТӨМӨР

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДЭД  
БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ОЮУНТУЯА

ШИНЖЛЭХ УХААН, ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙН  
ГАЗРЫН ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА



Ж.ТАМЖИД

БАГАХАНГАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
ПАРК ОНӨҮГ-ЫН ДАРГА



Ц.ЖАМБАЛЦЭРЭН


**БОЛОВСРУУЛСАН:**

ХБХГ-ЫН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ  
ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.ДАРХАНЧУЛУУН

ШИНЖЛЭХ УХААН, ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ИННОВАЦИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН




Ч.АМАРТҮВШИН

БАГАХАНГАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
ПАРК ОНӨҮГ-ЫН ТӨСЛИЙН ИНЖЕНЕР



И.ЦЭРЭНБАТ

<b>ЗАХИАЛАГЧ</b> Хот байгуулалт, хөгжлийн газар "Багахангай үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ	<b>ГАЗРЫН БАЙРШИЛ</b> Багахангай дүүрэг, 1-р хороо	<b>ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, БАРИЛГАЖИЛТЫН ТӨСӨЛ</b> Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн парк	<b>ТАЛБAYН ХЭМЖЭЭ</b> 56 Га
--------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------



Эрэгзэлийн цэргийдийн координатыг

№	X	Y
1	688628.1389	5246856.278
2	688697.2712	5247020.782
3	687063.0927	5247095.205
4	687089.2542	5246143.409
5	687215.7447	5247162.551
6	687215.7447	5247162.551
7	687668.3107	5246504.713

№	Тодорхойлолт
1	Төлөвлөгөөний бүх байршил
2	Одоо байгаа төмөр замын хэсэг
3	Одоо байгаа сувуу сувуу
4	"Багахангай" нэрээр "Хөгжлийн Технологийн Парк" байршил

**Танхим тэмдэг**

- Төлөвлөгөөний хил
- Балчирхай, барууламхай тэнгэр
- Дүүрсэн барилга, хажуу байршил
- Дутуу барилга, хажуу байршил
- Автозам, хажуу байршил
- Барилга, төлөвлөгөөний
- Дэд буталц, төлөвлөгөөний
- Авто зам, төлөвлөгөөний
- Эргэн зам, төлөвлөгөөний
- Эргэн зам, төлөвлөгөөний
- Хажуу хил
- Гэрээ усны жолоо
- Бусад усны жолоо
- Гэрээний байгууллага
- Цэцэрлэгийн дэд төлөвлөгөөний
- Цэцэрлэгийн дэд төлөвлөгөөний
- Цэцэрлэгийн тусгай тусгай 10 м-ийн
- Цэцэрлэгийн 100 м-ийн
- Цэцэрлэгийн 200 м-ийн
- Бусад төлөвлөгөөний
- Төлөвлөгөөний тусгай
- Автомобиль тусгай
- Хажуу тусгай
- Хажуу тусгай
- Хажуу тусгай

Масштаб 1: 10,000

Тусгааг : WGS 1984 UTM Zone 48N

НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР  
Ерөнхий архитектурын өмчийн алба  
Нийслэлийн Засаг захиргааны 2-р байр 1302 пост  
Утас: 11-32 1943, website: http://mra.ub.gov.mn

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН  
ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, БАРИЛГАЖИЛТЫН ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЗГААР**

Багахангай дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркний хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах зургийн далагварын хоёрдугаар хавсралт

### Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага

1. Солбицолын тогтолцоо: WGS84-UTM
2. Мэдээллийн санд хүлээлтэн өгч байгаа ерөнхий төлөвлөгөөний тоон зургийг 1:1 харьцаагаар зурж, \*.dwg, \*.shp өргөтгөлтэй бэлтгэнэ.  
> \*.dwg, /polyline, polygon, point, /Хүснэгт 1: Auto CAD програмын ХЕТ-ний даахарын стандарт  
> \*.shp /area, polyline, point, line, /Хүснэгт 2: ArcGIS програмын ХЕТ-ний даахарын стандарт
3. Байр зүйн тоон зургийг суурь болгон ашиглахдаа байр зүйн зургийн батлагдсан заавар, стандартыг баримтална.  
/Хүснэгт 3: Байр зүйн зургийн даахарын стандартыг хэсэрсгээв

- ### Мэдээллийн санд ерөнхий төлөвлөгөөний тоон зураг хүлээлтэн өгөх материал
1. Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг тоон хэлбэрээр /\*.dwg, \*.shp, \*.jpg, Sketch UP, 3d max файл/ хүлээлтэн өгнө.  
/CD-1 хуваь/
  2. Ерөнхий төлөвлөгөөг зөвшөөрөлдсөн, баталсан албан тушаалтны гарын үсэг болон зураг хийж гүйцэтгэсэн компанийн тамга, гарын үсэгтэй хэвлэмэл зураг.

















Байр зүйн зургийн давхаргын стандарт

Хүснэгт 3

Д/д	Layer-ийн бичиглэл	Үйлбэр	Color /Өнгө/	LineType /Зураасны төрөл/	Lineweight /Зураасны өргөн/	Таних тэмдэг
1	1	Байшин, барилга	White /ундсан цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
2	2	Байшин, барилгын пикет цэг	White /ундсан цагаан/	Dot /цагэн/	0.00	
3	3	Хатуу цэгийн өндрийн бичиглэл	White /ундсан цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
4	4	Газар дээрх холбооны шугам	Magenta /ундсан ягаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
5	5	Газар доорх холбооны шугам	Magenta /ундсан ягаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
6	6	Холбооны хуудар	Magenta /ундсан ягаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
7	7	Газар доорх цахилгааны өндөр хүчдлийн шугам	Red /ундсан улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
8	8	Газар доорх цахилгааны нам хүчдлийн шугам	Red /ундсан улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
9	9	Гарийн шон	White /ундсан цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
10	10	Хашааны пикет цэг	White /ундсан цагаан/	Dot /цагэн/	0.00	
11	11	Дулааны шугам	Red /ундсан улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
12	12	Дулааны хуудар	Red /ундсан улаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
13	13	Гол	Blue /ундсан хөх/	Continuous /үргэлжилсэн/	0.00	
14	14	Голын пикет цэг	White /ундсан цагаан/	Dot /цагэн/	0.00	
15	15	Ужсан нүх, овоолсон шорооны ирмэг	White /ундсан цагаан/	Continuous /үргэлжилсэн/	0.00	

Д/д	Layer-ийн бичиглэл	Тайлбар	Color	Өнгө/	LineStyle	Зураасны төрөл/	LineWeight	Таних тэмдэг
16	17	Ухсан нүх, овоолсон шорооны ирмэгийн жижиг цэг	White	Үндсэн цагаан/	Dot	Цэгэн/	0.00	
17	18	Насил	White	Үндсэн цагаан/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
18	19	Насилын жижиг цэг	White	Үндсэн цагаан/	Dot	Цэгэн/	0.00	
19	20	Хоолой	White	Үндсэн цагаан/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
20	21	Мод	Green	Үндсэн ногоон/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
21	23	Кабелийн TV-ийн төв шугам	Red	Үндсэн улаан/	Dashed	Гасархай/	0.00	
22	24	Кабелийн TV-ийн туслах шугам	Red	Үндсэн улаан/	Dashed	Гасархай/	0.20	
23	25	Зам, талбай	White	Үндсэн цагаан/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
24	26	Зам, талбайн жижиг цэг	White	Үндсэн цагаан/	Dot	Цэгэн/	0.00	
25	27	Бохирын шугам	Green	Үндсэн ногоон/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
26	28	Бохирын шугамын хуудар	Green	Үндсэн ногоон/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
27	29	Цэврийн шугам	Blue	Үндсэн хөх/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
28	30	Цэврийн шугамын хуудар	Blue	Үндсэн хөх/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
29	31	Ус зайлуулах хоолой	Blue	Үндсэн цэнхэр/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
30	32	Ус зайлуулах хоолойн хуудар	Blue	Үндсэн цэнхэр/	Continuous	Үргэлжилсэн/	0.00	
















D/L	Layer-ийн бичиглэл	Color /Өнгө/	LineType /Зураасны төрөл/	Lineweight /Зураасны өрөөл/	Таних тэмдэг
31	Бензин клонокийн шугам	Magenta /Ундсан ягаан/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	
32	Бензин клонокийн шугамын хурдаг	Magenta /Ундсан ягаан/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	
33	Төмөр зам	White /Ундсан цагаан/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	
34	Төмөр замын пикет цэг	White /Ундсан цагаан/	Dot /Цэгэн/	0.00	
35	Бүх текстэн бичиглэл	White /Ундсан цагаан/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	
36	Дижитализердсан цэг	White /Ундсан цагаан/	Dot /Цэгэн/	0.00	
37	Планшетний хурээ	White /Ундсан цагаан/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	
38	Улаан шугамны хурээ	red /Ундсан улаан/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	
39	Үргэлжилсэн рельеф	Brown /Өнгө 32/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	
40	Үндсэн рельеф	Brown /Өнгө 32/	Continuous /Үргэлжилсэн/	0.30	
41	Барилга байшингийн дугаар	White /Ундсан цагаан/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	
42	Пикет цэг	White /Ундсан цагаан/	Dot /Цэгэн/	0.00	
43	Өндрийн цагийн бичиглэл	White /Ундсан цагаан/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	
44	Top	White /Ундсан цагаан/	Continuous /Үргэлжилсэн/	0.00	


























АРХИТЕКТУР ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТ

Хүснэгт 4

Д/д	Тэмдэг	Өнгөний код	Бүсийн нэр	Зориулалт
1		C0; M62; Y100; K0	Хотын төв, олон нийтийн төв	1. Төр захиргаа 2. Худалдаа, үйлчилгээ 3. Нийгмийн дад бүтэц 4. Соёл урлаг, спорт
2		C18; M93; Y100; K10	Ажил хэргийн төв	1. Банк, санхүү, даатгал 2. Олон улсын худалдаа 3. Зочид буудал, бусад
3		C0; M90; Y100; K10	Хотын хөгжлийн тэнхлэг	1. Худалдаа үйлчилгээ 2. Орон сууц, олон нийт 3. Соёл урлаг, спорт
4		C2; M26; Y100; K10	Орон сууцны хороолол	1. Орон сууц 2. Олон нийт 3. Нийгмийн дад бүтэц
5		C6; M0; Y96; K0	Сайжруулсан гэр сууцны хороолол	Амьдрах нөхцөл сайжирч хэвээр үлдэх гэр хороолол
6		C65; M82; Y2; K0	Өндөр технологийн төв	1. Мэдээлэл технологи, парк 2. Өндөр тех-н үйлдвэр 3. ШУ-ны судалгааны төв
7		C29; M42; Y0; K0	Тээвэр логистикийн төв	1. Тээвэр жүүлчлал /төм. зам/ 2. Тээвэр жүүлчлал /авто/ 3. Тээвэр жүүлчлал /гаар/
8		C15; M94; Y0; K0	Холмог ашиглалтын нутаг дэвсгэр	1. Үйлдвэр-үйлчилгээ 2. Үйлдвэр-орон сууц 3. Орон сууц-үйлдвэр
9		C82; M50; Y37; K12	Үйлдвэр	1. Хүнс, хөнгөн үйлдвэр 2. Аж ахуйн газрууд
10		C62; M38; Y28; K12	Агуулах	Төрөл бүрийн агуулах
11		C76; M53; Y0; K0	Инженерийн барилга байгууламж	1. Дулаан, цахилгааны станц 2. Цахил. хув. байгууламж 3. Цэвэрлэх байгууламж
12		C37; M30; Y30; K0	Тусгай бүс	1. Нисэх онгоцны буудал 2. Цэргийн анги 3. Хорих газар 4. Хор хаях, оршуулга
13		C87; M21; Y95; K7	Ногоон байгууламж	1. Соёл амралтын парк 2. Цэцэрлэгт хүрээлэн 3. Амьтны хүрээлэн
14		C62; M0; Y76; K0	Хамгаалалтын бүс	Барилгажихыг хориглосон голуудын хамгаалалтын нутаг дэвсгэр
15		C63; M0; Y100; K0	Төмөр замын хамгаалалтын зурвас	Барилгажихыг хориглосон талбай

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүснэгт 5

Д/д	Тэмдэг	Өнгөний код	Бүсийн нэр	Зориулалт	
1		C41; M8; Y75; K0	Орон сууцны бүс	1. Эдгэлбэр газартай хувийн орон сууцны бүс	
		2; M19; Y35; K0		2. Нам давхрын орон сууцны бүс	
		C0; M27; Y100; K0		3. Дунд давхрын орон сууцны бүс	
		C7; M73; Y65; K0		4. Өндөр давхрын орон сууцны бүс	
		C6; M0; Y96; K0		5. Тэр хорооллын бүс	
2	   	C0; M89; Y100; K0 C9; M88; Y0; K0 C18; M87; Y100; K9 C57; M55; Y31; K6	Олон нийтийн ажил хэргийн бүс	1. Хотын олон нийтийн ажил төв/ хэргийн дэд бүс/Дүүргийн түвшний төв/ Хорооллын худалдаа ажил хэргийн бүс /Хорооллын түвшний төв/ 4. Үйлчилгээний төрөлжсөн бүс	
3	   	C25; M52; Y39; K1 C27; M22; Y22; K10 C55; M47; Y46; K22		Үйлдвэрийн бүс	1. Тээвэр бөөний худалдааны бүс /логистик/ 2. Хөнгөн үйлдвэрийн бүс 3. Тусгай үйлдвэрийн бүс
4	 	C79; M0; Y100; K0 C65; M0; Y8; K0			Ногоон байгууламжийн бүс
5	  	C73; M22; Y75; K53 C74; M17; Y1; K0 C65; M62; Y0; K0	Холимор ашиглалтын бүс	1. Үйлдвэр суурин холимор бүс 2. Худалдаа үйлдвэр суурин холимор бүс 3. Үйлдвэр худалдаа холимор бүс	
6	 	C76; M47; Y0; K0 C75; M68; Y67; K90		Инженерийн шугам сүлжээний бүс	1. Инженерийн барилга байгууламжийн бүс 2. Инженерийн шугам сүлжээний бүс /авто зам, төмөр зам/
7		C58; M85; Y0; K0	Тусгай зориулалтын бүс		Тусгай зориулалтын бүс